

НАРМАЙ МОНГОЛЫГ НЭГТГЭХ ХӨДӨЛГӨӨН (Товчлол)

ЖАН ЖИСЮН*

Халхын тусгаар тогтнолын хөдөлгөөн бол дан ганц гадаад Монголын тусгаар тогтнолын хөдөлгөөн мөн үү? Аль эсвэл халхаар төвлөсөн монгол үндэстнийг нэгтгэх хөдөлгөөн үү? Халхын тусгаар тогтнолын хөдөлгөөн ба Нармай Монголыг нэгтгэх хөдөлгөөн хоорондоо ямар холбоотой вэ? Энэ асуудал миний судалгааны, энэ өгүүллийн гол санаа юм.

Энгийнээр хэлбэл, Халхын тусгаар тогтнолын хөдөлгөөн бол гадаад Монголын тусгаар тогтнолын хөдөлгөөн мөн гэдэг нь судлаачдын тогтсон үзэл юм. Хэдийгээр энэ өгүүлэлд халхын тусгаар тогтнолын хөдөлгөөн нь зөвхөн дан ганц гадаад Монголын тусгаар тогтнолын хөдөлгөөн биш, харин ч Нармай Монгол үндэстний улсыг нэгтгэх хөдөлгөөн бөгөөд эхнээсээ эцсийг хүртэл маш сайтар төлөвлөсөн стратегийн бодлого, тэгээд ч түр зуурынх буюу боломжийг ашигласан хувирах ёстой үр дүн ч биш юм. Хэдийгээр, гадаад Монгол эхнээсээ л халхыг тусгаар тогтноулах, Их Монгол улс байгуулах зэрэг тавьсан зорилтондоо хүрч чадахгүй гэдгийг бодитойгоор ойлгож байсан. Ялангуяа тусгаар тогтносон улс байгуулах бүх монголыг нэгтгэх гэвэл, өөртөө байх ёстой бодитой хүч, чадвар дутагдана гэдгийг ч, тэр ч бүү хэл ялагдана гэдгээ ч сайтар ойлгож байсан юм. Нармай Монголыг нэгтгэх явдал ялагдсан нь монгол үндэстнийг нэгтгэх хөдөлгөөнийг ч төлөөлөөгүй, бас Гадаад Монгол өөрөө халхын тусгаар тогтнолын хөдөлгөөнийг ч зогсоох гэж санаагүй юм. Гэвч энэ өгүүлэлд түүхийн материалыг гүйцэд сайн задлан шинжилж, халхын тусгаар тогтнол нь Гадаад Монголын тусгаар тогтнолын ойрын зорилт, бөгөөд Нармай Монголыг нэгтгэх нь холын зорилт юм гэдгийг явцуу болон өргөн утгаар нь авч, судалгааны ухагдахуун, хэв маягийг тодорхойлохыг оролдсон юм.

Явцуу утгаар нь авч үзвэл, 1911 оны 7-р сарын 10-нд Хүрээнд болсон ноёдын нууц зөвлөлгөөнөөр хэлэлцсэн асуудал ба Манж Чин улсын сүүлчээр Монголын ноёд Манжийн засгийн газрын хэрэгжүүлж байсан шинэ засгийн бодлого ба харгис боолчлолоос эмээж, 1911 оны 7-р сарын 29-нд ноёд, лам нарын төлөөлөгч Хандлорж чин ван, да лам (хутагтын туслах, сангийн даамал) Цэрэнчимэд нарыг Оросод явуулж, хамгаалалт хүсэх, улмаар Орос

* Жан Жисюн - Тайваний төв академийн Шинэ түүхийн хүрээлэнгийн профессор, доктор

улсаас цэрэг гарч туслаж, Хятадаас салж тусгаар тогтноход туслахыг хүссэн юм. 1911 оны 11-р сарын 30-нд гадаад Монголын Богд Жавзундамбыг хаанд өргөмжилж, Монголын тусгаар тогтнолыг зарлан, хаан сууринд залж, өвөр, ар монголын олон аймаг хошуудад уриалга гаргажээ. Уриалга бичигт энэ жилийн Гадаад Монголын тусгаар тогтнолын хөдөлгөөн ба Нармай Монгол байгуулах хөдөлгөөний хооронд лавтай холбоотой болохыг задлан шинжилж, нотлон бичжээ.

Өргөн утгаар нь авч үзвэл, XX зууны эхээр Халхын тусгаар тогтнолын явцад төр шашны төв болгох, гадаад бодлогыг зохицуулах, цэрэг зэвсгийн хүчийг чангатгах, Нармай Монголыг байгуулах хөдөлгөөн оролдлого, алхам газар сайгүй илэрхий гарч байв. Юуны өмнө 1911 оны өвөл Халх нь Хаант Оросын өдөөлөг дэмжлэгээр тусгаар тогтнолоо зарлав. Халх шашны тэргүүн Жавзандамба хутагтыг хаан гэж шүтэж, улмаар төв засгийн газар байгуулж, улс үндэстний хүлээн зөвшөөрсөн төв байгуулан, төрийн бодлогыг явуулах нармай Монголыг байгуулах эрх бүхий байгууллага бий болгов. Мөн стратеги төлөвлөгөөний дагуу, халхыг нэгтгэх явдлыг урагшлуулж, тэгээд цэрэг гаргаж Улиастай, Ховдыг авах 4 аймгийг нэгтгэх, мөн зүүн Монгол, баруун Монгол, өмнөд Монгол зэрэг Өвөр Монголын олон аймаг хошуунд элч явуулж, уриалгыг сурталчлах, Богдыг хаан ширээнд суусан, гадаад Монгол тусгаар тогтнох, Монголыг нэгтгэх зэрэг хэрэг явдлыг зарлах, Өвөр Монголыг Хүрээнд захируулах өдөөлөг хийж, улмаар хойт Монголд санаархсан уриалга бичиг тарааж (Оросын хил доторхи буриад монгол) Их Монголын хаант улс байгуулахыг санаархаж байв.

Мөн оны өвөл, Жавзандамба хутагт нэг талаар лам нарыг Өвөр Монголын олон хошуунд илгээж ноёд, лам нарыг дагаар орохыг ятгаж, нөгөө талаар гурван замаар их цэрэг гаргаж, баруунаас өөлд дунд хошуу, хойт хошуу, зүүнээс Шилийн гол аймгийн бүх хошуунд халдан орж, зэвсгийн хүчээр Өвөр Монголыг эзлэн авах, өвөр, ар монголыг хүчээр нэгтгэх Их Монгол Улс байгуулахаар санаархаж байв.

1912 онд, Хөлөнбуйрын удирдагч Шэн Фу Халх Монголын шашин, төрийн удирдагч Жавзундамба хутагт хааны уриалгаар, Монголын хааны үгийг дагаж, Монгол улсын нэг хэсэг болсон юм. Орос Монголын хэлэлцээрт гарын үсэг зурсны дараа ч Орос улс Хүрээний Засгийн газрыг бүрэн эрхт тусгаар тогтносон улс гэж хүлээн зөвшөөрөөгүй бөгөөд Монгол улс Оросын хамгаалтан дор автомонит гадаад Монгол болон Халхын 4 аймаг түүний захиргааны нутаг болон хязгаарлагдаж, гадаад Монголын Өвөр Монголыг улс төрийн аргаар нэгтгэх гэсэн санаархал даруй сүйрэн унаж, гаднын тусламж авах

гэсэн цорын ганц зам нь таслагдсан юм. Хэдийгээр ийм байсан ч гадаад Монгол зүрх мөхөлгүй, Өвөр Монголд “орж, гарсаар” байв. Гэхдээ Хөлөнбуйр нь Гадаад Монгол Оросын хамгаалалтанд найдаж буйг ойлгож мэдээгүй, өөрөө Орос улсыг түшиглэхгүй автономит болохыг хүсэж байв. Ингээд Хөлөнбуйрыг нэгтгэх гадаад Монголын төлөвлөгөө эцэстээ талаар болсон юм.

1913 онд Хятад, Орос гарын үсэг зурсан тунхагийн (мэдэгдэл) баримт бичиг ба түүний хавсралтанд зааснаар Орос улс Хятадын гадаад Монгол дахь сюзернитет болон гадаад Монголын нутаг дэвсгэрийг Хятадын нэг хэсэг мөн гэдгийг хүлээн зөвшөөрч, Хятад улс гадаад Монголын автономит эрхийг хүлээн зөвшөөрсөн юм. Хууль ёсоор, гадаад Монгол тусгаар тогтнож чадахгүйгээр үл барам, Хятадын сюзернитетийг хүндэтгэн сахих ёстой, Хятадын газар нутгийн бүрэн бүтэн байдлын нэг хэсэг гэдгийг тогтоосон юм. 1914 онд, Хятад, Орос, Монгол гурван тал тунхагийн баримт бичгийг үндэслэн, Хиагтал хуралдаж, Монголын асуудлыг шийдвэрлэв. 1915 онд Хятад, Орос, Монголын хэлэлцээр хийж, Монгол улсын цолыг хүчингүй болгохоор тогтож, гадаад Монголын автономит засгийн газар гэж өөрчлөн нэрлэж, Жавзандамба хутагтын хааны цолыг хүчингүй болгож, гадаад Монголын Богд Жавзандамба хутагт хаан гэх болж, Дундад иргэн улсын дазунтун - (их ерөнхийлөгч) авав. Мөн оны цолыг устгаж, иргэн улсын он тооллыг авсан ба гэхдээ Монголын он тооллыг хэрэглэх болов. Ингээд гадаад Монгол бүх Монголыг нэгтгэх аргагүй болж, Монгол улсын байр суурийг хадгалах аргагүйд хүрч, тэр ч байтугай төв засгийн газрын нэрийг хэрэглэхийг бас хориглов. Ингээд байдал түргэн өөрчлөгдөж Гадаад Монголын тусгаар тогтнолын хөдөлгөөн ба нэгтгэх хөдөлгөөн сая бүрэн ялагдах хүлээв.

Өргөн утгаар нь авч хэлбэл, Халх юуны өмнө, улс төрийн байгууллага ба төр шашныг хослон явуулах, дараа нь цэрэг зэвсгийн хүчээр болон дипломат бодлого хэрэглэн Халхыг нэгтгэх, нармай Монгол үндэстнийг нэгтгэх хөдөлгөөнийг аажмаар өргөжүүлсэн нь нэгэн үндэстний тусгаар тогтнолын хөдөлгөөн бүхий л үндэстнийг нэгтгэх чиглэлийг бадруулж болно гэдгийг харуулж байна. Энэ өгүүлэлд халхын тусгаар тогтнолын хөдөлгөөний төслийг гол болгон Хятад, Оросын гадаад бодлоготой зохицуулах улмаар Өвөр Монголд “орж гарах”-ыг далимдуулан Нармай Монголыг нэгтгэх хөдөлгөөнийг урагшлуулах санаархлыг задлан шинжлэв.

Мөн Оросын тал гадаад Монголыг Хятадаас тусгаарлах явдлыг хүчтэй дэмжиж, автономитыг хязгаарласан ч тусгаар тогтноулж чадаагүй юм. Өөрөөр хэлбэл, “Гадаад Монголын тусгаар тогтнол” бол орос маягаар (улсын доторхи улсын) автономи бөгөөд өрнөдийн сувернитет хэлбэрийн улсын байдал биш юм. Гадаад Монгол Өвөр

Монголыг таягдан хаяж чадахгүй, биеэ бодоод бусдыг хайхрахгүй байж чадаагүйн улмаас Оросын тал Өвөр Монголыг орхиж, хайхраагүй бөгөөд гадаад Монгол ч Өвөр Монголтой хамтдаа Хятадын захиргаанд орохыг огт бодоогүй юм. Оросын тал эцэстээ Гадаад Монгол Нармай Монгол улсыг байгуулж чадахгүй, Гадаад Монголын асуудлыг умар зүгт Орос улс дайнаар шийдвэрлэх, өмнө зүгт Хятад улс дайнаар шийднэ гэж ойлгож байв. Хэрэг дээрээ, тухайн үеийн түүхэн байдлыг харахад, Гадаад Монгол Нармай Монголыг нэгтгэх явдлыг хэзээд эс мартаx бөгөөд, тэгээд ч нармай Монголоос Хүрээ дагах, цэрэг гаргаж Өвөр Монголыг авах зэргийг ч мартаж чадахгүй юм.

Эндээс үзэхэд, Халхын тусгаар тогтнол ба дан ганц гадаад Монголын тусгаар тогтнол биш, мөн чанартаа нармай Монголын тусгаар тогтнолыг гол болгосон юм. Иймээс Нармай Монголыг нэгтгэх хөдөлгөөн бол Халхын тусгаар тогтнолын хөдөлгөөний хамгийн сүүлчийн үе шат, түүнчлэн Халхын тусгаар тогтнолын хөдөлгөөн бол Нармай Монголыг байгуулах хөдөлгөөний анхдагч үе шат мөн.

Хятад хэлнээс орчуулсан Л.Бэгзжав